



2009 оны 12 дугаар
сарын 11 -ны өдөр

МЖХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР

Дугаар 03

Улаанбаатар хот

САХИЛГА, ДЭГ ЖУРАМ, ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг өндөржүүлэх, өвөлжилтийн явцад гарч болзошгүй хүндрэлтэй асуудалд онцгой анхаарах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас даалгах нь:

Нэг. Дараахь арга хэмжээг авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1.1. төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг өндөржүүлэн, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн хүрээнд аль болох хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэж ажиллах талаар бодитой ажил зохион байгуулж тодорхой ахиц гаргах;

1.2. Засгийн газрын шийдвэрээр гадаадад томилолтоор ажиллахаас бусад тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга нар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нар эрхэлсэн сайдаасаа зөвшөөрөл авсны үндсэн дээр гадаадад явж байх;

1.3. ажлын байрандаа болон албан үүргээ гүйцэтгэж явах үедээ архи, согтууруулах ундаа хэрэглэх асуудлыг таслан зогсоож, зөрчсөн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож байх;

1.4. төсвийн хөрөнгийн зарцуулалтыг ил тод болгон батлагдсан хөрөнгөө зориулалтын дагуу хэтрүүлэхгүй зарцуулж үргүй зардлыг багасган хэмнэлтийн горимыг чанд сахиж ажиллах;

1.5. аймаг бүр өвөлжилтийн байдал хүндэрсэн үед шуурхай арга хэмжээ авах, бодитой мэдээллээр хангах, гарч болзошгүй хүндрэлийг арилгах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий салбар ажлын хэсгийг Засаг даргаар ахлуулан байгуулж ажиллуулах;

1.6. өөр аймаг, сумаас гэрээний дагуу отроор өвөлжиж байгаа малчдаас хууль бус татвар хураамж нэхэх, дарамт шахалт үзүүлэхгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах;

1.7. отроор өвөлжиж байгаа малчдад үйлчилгээг шуурхай хүргэх, тэдгээрийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, хүн, малыг эмчлэх, тэдэнд хүнс, бараа, материалын худалдаа, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг тогтмол авч байх;

Хоёр. Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулиар баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулж, үр дүнг дээшлүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

2.1. 2010 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсөл, арга хэмжээ бүрээр энэ оны 12 дугаар сард багтаан баталж 2010 оны 2 дугаар сарын 1-ний дотор улсын хэмжээнд бүх тендер зарлагдаж, 4 дүгээр сарын 1-ний дотор тендер шалгаруулалтыг дүгнэж дуусган гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажлыг нь эхлүүлсэн байх;

2.2. тендер шалгаруулалтын онцгой журам болох харьцуулалтын болон гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхдээ хууль зөрчихгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1 дэх хэсэгт заасан босго үнээс өндөр төсөвт өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулах;

2.3. тендерийн урилга, үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим сүлжээнд /www.e-procurement.mn/ цаг хугацаанд нь бүрэн гүйцэд, үнэн зөв тавьж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг нээлттэй, ил тод мэдээлж байх;

2.4. захиалагч бүр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан захиалагчийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

2.5. 2010 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулж, ажлыг нь эхлүүлэх хүртэл хугацаанд яам, агентлаг, аймаг, нийслэлийн төсвийн ерөнхий менежерийг гадаадад томилолтоор явуулахгүй байх;

2.6. Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулиар батлагдсан урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явцын талаарх дүнг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлж байх.

Гурав. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, аливаа зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг цаг тухайд нь авч ажиллахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгаж байна.

Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын худалдан авах ажиллагаанд хууль тогтоомжийг чандлан мөрдүүлэх, зөрчил гаргасан албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллахыг Төрийн өмчийн хороо /Д.Сугар/, төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгож байна.

Тав. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт үүрэг болгож байна.



Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД